

БАТЛАВ

НИЙСЛЭЛИЙН ЗАМЫН ХӨГЖЛИЙН
ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Г.БАЯРСАЙХАН

ГЭРЛЭН ДОХИОНЫ ЗАСВАР АРЧЛАЛТ, СИСТЕМИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ,
ГАДНА ТАЛБАЙН БУСАД ТОНОГ ТӨХӨӨРӨМЖҮҮДИЙН ЦАХИЛГААН,
ТЭЖЭЭЛ, ХУДАГ СУВАГЧЛАЛЫН ЗАСВАР АРЧЛАЛТ
ХИЙХ АЖЛЫН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

1. Ерөнхий зүйл

1.1 Замын хөдөлгөөний удирдлагын төвийн ашиглалтад байдаг Улаанбаатар хотын гудамж замуудад суурилагдсан авто замын хөдөлгөөн зохицуулах гэрлэн дохионы хэвийн найдвартай ажиллагааг хангах, арчлалт хамгаалалт, засвар үйлчилгээ цэвэрлэгээ хийх болон автозамын хяналтын камер, зөрчил бүртгэх камер зэргийн цахилгааны үндсэн тэжээлийн гэмтлийг засварлах зэрэг ажлыг хийж гүйцэтгэнэ.

Үүнд: Гэрлэн дохионы LSU, CPU, FLASH, COUNT хавтангууд, гэрлүүдийг солих, бусад төрлийн бүхий л эвдрэл гэмтлийг засварлах, гэрлэн дохионд бүх төрлийн цэвэрлэгээ хийх, цахилгааны кабелийн болон үндсэн тэжээлийн гэмтлийг засах, кабелийн сувагчлал хийх, сэргээх, тоног төхөөрөмжүүдийг зөөн шилжүүлэх, өргөтгөх, буулгах, газар шорооны гэх мэт ажлуудыг хийнэ

2. Үйл ажиллагаа, хариуцлага

2.1 Гүйцэтгэгч нь гэрлэн дохио болон бусад гадна тоног төхөөрөмжүүдийг засварлахад шаардагдах техник хэрэгсэл, хүн хүч зэргийг 24 цагийн турш бэлэн байлгаж захиалагчийн өгсөн захиалгын дагуу эвдэрсэн тоног төхөөрөмжүүдийг түргэн шуурхай засварлах үүргийг хүлээнэ.

2.2 Захиалагчийн өгсөн үүрэг даалгаврын дагуу гэрлэн дохио болон бусад гадна талбайд байрлах тоног төхөөрөмжүүдийг засварлахдаа гүйцэтгэгчийн засварын ажлын буруу болон үүрэг даалгаврыг хугацаанд нь гүйцэтгээгүйгээс үүдэн гарсан аливаа хохирол, зам тээврийн ослын хохирлыг гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.

2.3 Гэрээний хугацаанд хийж гүйцэтгэх ажлын тоо хэмжээ болон нэр төрөлд өөрчлөлт орж болно.

2.4 Захиалагчийн өгсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй, дутуу буруу хийсэн тохиолдолд захиалагч тал гэрээг цуцлах үндэслэл болно.

3. Санхүүжилт, ажлын тайлан

3.1 Гүйцэтгэгч нь гүйцэтгэлээрээ санхүүжнэ.

3.2 Засвар арчлалтын ажлын явцыг фото зургаар заавал баримтжуулна. Фото зургаар баримтжуулаагүй ажлыг хүлээж авахгүй болно.

3.3 Гүйцэтгэгч нь тухай бүрийн засварын арчлалтын ажлыг эхлэхээс өмнө болон дууссаны дараа мэдэгдэж сар бүр хийсэн ажлаа тайлагнаж гүйцэтгэлийг захиалагч талд хүргүүлнэ.

3.4 Гүйцэтгэгчийн хийсэн ажлыг захиалагч талын хяналтын инженерүүд болон холбогдох албан тушаалтнууд акт үйлдэн хүлээн авна.

4. Шаардагдах машин механизм, техник хэрэгсэл, ажлын багаж

Үүнд:

- Өөрийн эзэмшлийн байх 3 тонн ачааг өргөж даах авто крантай байх,
- Засварчныг 10 метр өндөрт өргөх боломжтой өөрийн эзэмшлийн хүн өргөгч авто машинтай байх,
- Шон, шонгийн суурь, сэлбэг хэрэгсэл болон бусад багаж хэрэгсэл ачих ачааны зориулалтын өөрийн эзэмшлийн 5 тонн буюу түүнээс дээш даацтай машинтай байх,
- 220 вольтын цахилгаан үүсгүүртэй байх,
- Газар шорооны ажил хийх, цахилгааны засвар хийх бусад багаж хэрэгслүүд /Цахилгааны тусгай зөвшөөрөлд шаардагдах багаж хэрэгслүүд/


5.Төлөвлөгөөт ажил

5.1 Жилд 1 удаа бүх гэрлэн дохионд үзлэг шалгалт хийж тэмдэглэл хөтөлнө.

5.2 Бүх уулзвар замын гэрлэн дохионы харагдах байдлыг сайжруулах цэвэрлэгээг жилд 1 удаа хийнэ.

Хянасан:

Замын хөгжлийн газрын засвар
арчлалтын хяналтын хэлтсийн дарга



О.Энхбаатар

“Замын хөдөлгөөний удирдлагын төв
ОНӨТҮГ-ын захирал



Ч.Хувьзаяа

Боловсруулсан:

Мэдээллийн технологи, техник ашиггалтын
хэлтсийн ахлах мэргэжилтэн



Г.Алтаншагай